



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

**ЗӨВЛӨМЖ № 19**

2022 оны 06 дугаар сарын 20

Номгон

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн дотоод аудитын хорооны тогтоолоор батлагдсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын баталсан 04 дүгээр удирдамж, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Засаг даргын эрхлэх хүрээний төсвийн байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагуудын дүгнэлтээс нэгдсэн судалгааг гаргаж сумын Засаг даргын Тамгын газруудад илэрсэн зөрчлүүдэд үндэслэн зөрчлийг давтахгүй, эрсдэлийг бууруулж урьдчилан сэргийлэх, төсвийн сахилга батыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны "Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

2. Тухайн онд хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг байгууллагын дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах. Тухайлбал:

- Жил бүр ижил дотоод хяналтуудыг хийх бус хамгийн их зөрчил, эрсдэл дагуулах ажлуудад дотоод хяналт хийхээр төлөвлөх

- Дотоод хяналтын нэгжийн ажлын төлөвлөгөөнд өмчийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт гэдэг ерөнхий нэрээр тусгалгүй, цалин тогтоолт, олголтонд хийх хяналт, цаг бүртгэлийн систем, ажлын цаг ашиглалтад тавих хяналт гэх мэт нарийвчлан тусгаж, журмын дагуу удирдамжийн хүрээнд шалгаж, тайлангаар баталгаажуулж, тухай бүр зөвлөмж гарган үр дүнг тооцож ажиллах.

3. Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдлыг сайжруулах, хагас бүтэн жилээр тооллого тооцоог бодитой чанартай хийж, ашиглагдахгүй болон актлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж, шийдвэрлүүлж байх.

Шийдвэрлэлтийн үр дүнг тооцож, хурлын тэмдэглэлээр ажлын хэсгийн ажлыг дүгнэж, хөрөнгийг тооцоо бодсон актаар баталгаажуулж, үр дүнг тооцох, Байгууллагын албан хаагчдын эзэмшиж байгаа эд хөрөнгийн картыг бүрэн хөтлөөгүй, албан хаагчдын гарын үсгээр албажуулаагүй, хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолоогүй, тооллогоор тоолсон үндсэн хөрөнгийн дүн бүртгэлийн дүнгээс зөрүүтэй байдлыг таслан зогсоох.

4.Ажилтан, албан хаагчдын цалинг төрийн албаны нэгдсэн систем, санхүүгийн програмтай уялдсан байж цалин болон ээлжийн амралт, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТатварын тайлангаар зөрүүгүй тайлاغнах.

5.Аж ахуйн материал, Түлш шатахуун, бусад хангамжийн материалын тайланг зөрүүгүй тайлагнах.

6.Байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөц, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлж шилэн дансны мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт хугацаанд нь мэдээлж, тайланг илгээх.

7. Өмнөх онд үүссэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллаж Төсвийн тухай хуулийн 4 зүйлийн 4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх

8.Тайлант хугацааны мөнгөн гүйлгээний “и” баримт болон анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийхгүй байх.

9.Байгууллагын даргын тушаалаар ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд үр дүнгийн урамшуулалт олгохыг шийдвэрлэхгүй, олгохгүй байх.

10.Төсөл хөтөлбөр, хандив тусламж бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг тухай бүрт нь орлогод авах.

11.Төсвийн шууд захирагч нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, гэрээний үүргээ биелүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмууд, 16 дугаар зүйлийн Төсвийн шууд захирагчдын төсвийн талаарх бүрэн эрхийг хэрэгжүүлэх, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасан бүх шатны төсвийн захирагчийн төсвийн хэрэгжилтийн талаар хүлээх үүргийг биелүүлэх, Ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан эрх, үүргийг тус тус хэрэгжүүлж ажиллах.

12. Санхүүгийн тайлангийн бараа материалын тусгай зориулалтын дансанд бүртгэлтэй мал амьтан, өвс тэжээлийг байгууллагын даргын шийдвэрээр бараа материалын данснаас хасах, нотлох баримт үндэслэх.

14. Санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж бүрэн барагдуулж, орон нутгийн орлогод төвлөрүүлж, өглөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй, өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй найдваргүй авлага үүсгэхгүй, таслан зогсоох. (Өвс тэжээлтэй холбоотой гэх мэт) Тухайлбал: Сум хөгжүүлэх зээлийн эргэн төлөлт хангалтгүй бөгөөд нийт зээл хугацаа хэтэрснийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.

15. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар төсөвт нэмэгдүүлэх, бууруулах төсвийн зохицуулалт хийвэл сумын ИТХ-ын хуралдаанаар өөрчлөлтийг батлуулах.

16. Байгууллагын эзэмшил болон шилжсэн автомашины өөрийн байгууллагын эзэмшлийн гэрчилгээжүүлэх, хувийн хэрэг, гэрчилгээний зөрчилгүй байх, Тухайлбал: Хог тээврийн хэрэгслийн бичиг баримтны зөрчлийг арилгах.

17. Ажлын гэрээг сумын Засаг дарга байгуулж, хөрөнгө зарцуулахаар захирамжилж аж ахуйн нэгж байгууллагад илүү дутуу шилжүүлсэн бол санхүүгийн тайландаа өглөг, авлагаар тусгах.

18. Тайлан жилд тоног төхөөрөмжийн өртөгт шилжүүлсэн ч тайлант жилдээ тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй бол авлагад бүртгэх.

19. Тэмцээнд оролцох баг тамирчдад нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас тоглолтын хувцас хийлгэх зориулалт бус зардлыг таслан зогсоох.

20. Хөтөлбөр, ээлжит чуулганыг зохион байгуулж, тоног төхөөрөмж, хөрөнгө худалдан авсан бол орлогод авах.

Ойлгомжгүй эргэлзээтэй асуудлыг тодруулах, ойлголтоо бататгах зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө мэдээллийг тухай бүр авч байх.

**ХЯНАСАН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООДАУДИТЫН

АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ДАВААЖАРГАЛ

**БИЧСЭН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН

АХЛАХ БАЙЦААГЧ

Л.ЖАРГАЛЦЭЦЭГ

